



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2018.03.14 № 1/368  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМАНД

**Тендер шалгаруулалтын тухай**

Танай яамнаас зарласан УУХҮЯ/201801001 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцогч “Грийн Химистри” ХХК-иас уг тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд холбогдох гомдлыг тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж, шийдвэрлэх хүртлэх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбогдох баримт материалаа 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА

Б.ЛХАГВА

Б.



0091043



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>

2018.03.23 № 04/494  
танай 2018.03.14-ны № 1/368 -Т

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗРЫН  
ДАРГА Б.ЛХАГВА ТАНАА**

Манай яамнаас зарласан УУХҮЯ/201801001 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерийг “Грийн Химистри” ХХК-иас гаргасан гомдлын дагуу танай газраас түдгэлзүүлээд байгаа билээ.

Тус компанийн гаргасан гомдолд өгөх тайлбар, тендерийн бичиг баримт, холбогдох материалыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт <sup>89</sup> хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ХОРООНЫ ДАРГА  М.БАЯРАА



08 0421



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 01 сарын 12

А/11

Улаанбаатар хот

Тендерийн үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, мөн 9.8 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Тендерийн үнэлгээний хорооны дарга:

М.Баяраа Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

Гишүүд:

Н.Цогтбаяр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн;

Н.Нямхүү Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн;

Ц.Эрдэнэбаяр Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лабораторын дарга;

Ц.Цэрэндаш Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлийн гишүүн /тохиролцсоноор/;

П.Бат Монгол Улсын өрөмдлөгийн холбоо ТББ-ын тэргүүн /тохиролцсоноор/

Нарийн бичгийн дарга:

Д.Даваабаяр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын газрын мэргэжилтэн.

2. 2018 онд шинээр хэрэгжүүлэх Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулахыг тендерийн үнэлгээний хорооны дарга /М.Баяраа/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ц.Одхүү/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

08 0044

## ТАЙЛБАР

“Грийн Химистри” ХХК-иас гаргасан гомдлын дагуу тайлбарыг гаргав.

1. Техникийн тодорхойлолтын стандарт, тайлбар хэсэгт Хийн хромаграф багажны үзүүлэлтийг Agilent 7890A хийн хроматограф GC (PONA) маркийн багажны техникийн шаардлага, үзүүлэлттэй дүйцэхүйц, Хүхрийн агуулга тодорхойлох багаж нь NXS-2100 маркийн багажны үзүүлэлттэй дүйцэхүйц, Автомат нэрлэгийн багаж нь OPTIDIST PAC маркийн багажтай дүйцэхүйц байна гэж тус тус зааж өгсөн тул энэ аливаа нэг хүссэн брендийн нэрийг тухайлан заасанд тооцогдохгүй гэж үзэж байна. Бид шаардлага хангасан, орчин үеийн, нарийвчлал өндөртэй сайн чанарын багаж, тоног төхөөрөмж авахаар зорьж байгаа учир багажнуудын техникийн шаардлага, үзүүлэлтүүдийг нарийвчлан зааж өгсөн. Тухайн багажнууд нь сүүлийн үеийн загвар хийцтэй, автомат ажиллагаатай, тоон үр дүнгийн нарийвчлал өндөртэй, шаардлага хангасан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үйлдвэрээс нийлүүлэгдсэн байх шаардлагыг тавьж байна.
2. Техникийн үзүүлэлтийг нэг бүрчлэн зааж өгснөөр бид шаардлагад нийцсэн орчин үеийн, өндөр нарийвчлалтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, сайн чанарын багаж, тоног төхөөрөмж худалдан авах, стандартын дагуу дээжийг шинжлэх үүднээс багаж, тоног төхөөрөмжийн иж бүрдлүүдийн техникийн үзүүлэлтийг нарийн, хатуу зааж өгөх зайлшгүй шаардлагатай байсан болно.
3. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийн барааны тодорхойлолт хэсэгт Optidist загварын, NXS-2100 загварын, CAV 2100 загварын гэж загвартай дүйцэхүйц гэсэн үгийг орхигдуулсан техникийн алдаа гарсан байх тул алдааг засаж, залруулга хийнэ.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн бараа, ажил, үйлчилгээг шалгаруулах бөгөөд тендерт санал болгосон тухайн бараа нь захиалагчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байх ёстой. Бидний худалдан авахаар төлөвлөж байгаа 11 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжүүд нь сүүлийн үед манай улсад тулгамдаад буй Агаар, орчны бохирдлыг бууруулах, автобензин, дизелийн түлшний чанарын асуудлыг шийдвэрлэх, чанар стандартын талаар үнэн зөв шинжилгээ, туршилтын дүгнэлт гаргах, хэрэглэгчдийг чанар, стандартын шаардлагад нийцсэн сайн чанарын шатахуунаар хангахад чухал ач холбогдолтой учир багаж, тоног төхөөрөмжийн техникийн шаардлага, үзүүлэлтүүдийг нарийвчлан зааж өгсөн болно.

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

## Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл. №01

2018 оны 1 дүгээр сарын 24 өдөр

**Хурал хийсэн газар:** УУХҮЯ-ны ТЗУГ-ын даргын 212 тоот өрөө, 15:00 цаг

**Хуралд оролцсон хүмүүс:** Тендерийн үнэлгээний хорооны дарга М.Баяраа, гишүүд Н.Нямхүү, Н.Цогтбаяр, Ц.Цэрэндаш, Б.Бат, Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Д.Даваабаяр нар оролцож 85%-ийн ирцтэй хуралдав.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай УУХҮЯ-ны ТНБД-ын тушаалыг танилцуулах.
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн батлагдсан төсвийн талаарх товч мэдээлэл өгөх.
3. Гишүүдээс үнэлгээний хороонд ажиллах тухай мэдүүлэг бөглүүлж авах.
4. Төсвийн хөрөнгөөр 2018 онд Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторын тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийн шалгаруулалтын үйл ажиллагаа, бичиг баримттай холбоотой саналыг гишүүдээс авах.
  - Тендерийг хэдэн багц болгон зарлах
  - Тендерийн бичиг баримт, техникийн тодорхойлолтыг боловсруулах хугацааг товлох.
  - Тендерийн урилгыг цахим хуудсанд байршуулж, тендерийг эхлүүлэх хугацааг товлох.
  - Тендерт оролцогчид тавих шалгуурыг тогтоох.

**М.Баяраа:** Тендерийн үнэлгээний хорооны дарга.

Төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторын тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны анхдугаар хурал болж байна. Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ТНБД-ын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/11 тоот тушаал гарсан байгаа. Тендерийн үнэлгээний хорооны даргаар миний бие ТЗУГ-ын дарга М.Баяраа, гишүүдээр Н.Нямхүү ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн, Н.Цогтбаяр ХШҮДАГ-ын мэргэжилтэн, Ц.Эрдэнэбаяр АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторын дарга, Төрийн бус байгууллагыг төлөөлж Ц.Цэрэндаш Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлийн гишүүн, П.Бат Монгол улсын өрөмдлөгийн холбооны тэргүүн, нарийн бичгийн дарга Д.Даваабаяр Түлшний бодлогын газрын мэргэжилтэн нар томилогдсон байна.

Тус тушаалаар 2018 онд Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулахыг тендерийн үнэлгээний хорооны дарга М.Баяраад, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХШҮДАГ-ын дарга Ц.Одхүүд тус тус даалгасан байна.

Гишүүдэд үнэлгээний хороонд ажиллах тухай мэдүүлгийн маягыг тараагаад өгнө, гишүүд Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг болон Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бөглөж өгөх нь байна.

Тендерийн талаар нарийн бичгийн дарга товч мэдээлэл хийх үү.

**Д.Даваабаяр:** Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга.

Тухайн тендерийн талаар ерөнхий мэдээллийг гишүүдэд танилцуулъя. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны багцад Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторын тоног төхөөрөмж худалдан авахад 1,2 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер нь нээлттэй тендерийн журмаар явагдана. Тус лабораторийн тоног төхөөрөмжийн эцсийн хэрэглэгч нь манай АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лаборатори байгаа. Уул уурхай, газрын тосны төв лабораторийн дарга Ц.Эрдэнэбаяр тендерийн үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон. Үнэлгээний хорооны гишүүн Ц.Эрдэнэбаяр лабораторид шаардлагатай, худалдан авах тоног төхөөрөмжийн талаар өнөөдрийн хурал дээр танилцуулга хийхээр төлөвлөсөн боловч сургалттай байгаа тул хуралд оролцож амжихгүй, чөлөө хүсч байгаагаа мэдэгдэн тус лабораторийн мэргэжилтэн Энхтүвшинг мэдээлэл, танилцуулга хийлгэхээр явуулсан байна. Тэгэхээр лабораторийн төлөөллийг хуралд оруулан мэдээлэл, танилцуулгыг хийлгэх үү? Гишүүд ямар саналтай байна зөвшөөрч байна уу?

**М.Баяраа:** Тендерийн үнэлгээний хорооны дарга.

Хэдийгээр Ц.Эрдэнэбаяр чөлөөтэй байгаа боловч Үнэлгээний хорооны ирц хангалттай бүрдсэн байна. Гишүүдэд мэдээлэл өгөх үүднээс лабораторийн төлөөллөөр мэдээлэл хийлгэе гэж бодож байна.

**Гишүүд:** Тэгье тэгье. Мэдээллийг сонсоё.

Уул уурхай, газрын тосны төв лабораторийн төлөөлөл Энхтүвшин газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторид шаардлагатай байгаа, худалдан авахаар төлөвлөсөн багаж, тоног төхөөрөмжийн талаар танилцуулга, мэдээлэл хийв.

**Д.Даваабаяр:** Уул уурхай, Газрын тосны тосны төв лабораторид шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг худалдан авч, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинжилгээний ажлын үр дүнг сайжруулах, жигдрүүлэх зайлшгүй шаардлага, тодорхой үндэслэлүүд нэлээд бий. Тухайлбал, Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-ийн 4.3.2-т “Евро 5 стандартад нийцсэн, чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, уг стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортлох, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах” гэж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.1-т “Автобензин, дизель түлшний Евро-5 стандартын жишигт нийцсэн Үндэсний стандарт” боловсруулж батлуулах, 3.2.2-т “Төрийн өмчийн итгэмжлэгдсэн лаборатори” бий болгох гэсэн заалтууд тусгагдсан. Евро-5 стандартын жишигт нийцсэн Үндэсний стандарт 2017 оны 04 дүгээр сард батлагдсан байгаа. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, шатахууны хяналтын тогтолцоог сайжруулах, стандартын шаардлагыг хангуулахад Уул уурхай, газрын тосны лабораторийн хүчин чадлыг сайжруулах, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

**Ц.Цэрэндаш:** Эдгээр худалдан авах тоног төхөөрөмж маань бүгд гадаадаас оруулж ирэх тоног төхөөрөмж байгаад байна уу?

**Д.Даваабаяр:** Тийм ээ. Евро-5 стандартын шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг тодорхойлох, тус стандартад заасан үзүүлэлтийг шинжлэхэд орчин үеийн, өндөр

технологийн, техникийн үзүүлэлт, нарийвчлалтай багаж, тоног төхөөрөмж шаардагдах юм. Тийм болохоор өндөр хөгжилтэй улс орнуудад үйлдвэрлэгдсэн багаж, тоног төхөөрөмж байх хэрэгтэй болно.

Гишүүд нэмэлт асуулт асуув.

**М.Баяраа:** Дараагийн хурал хэзээ вэ? Дараагийн хурлаас өмнө Ц.Эрдэнэбаяр ирсэн байх юм уу. Ер нь бол нарийн бичиг дор дор нь юмаа яриад явж байсан нь дээр байхаа АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораториос тодотгох зүйлүүдээ асуу, ер нь бол танайх ийм чухал шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах гэж байгаа байж энэ асуудалд нэлээд хариуцлагатай, нухацтай хандана шүү, энэ бол бага төсөв биш, эндээс өнөөдөр нэг шийдвэртэй гарах нь зүйтэй байхаа. Мэдээллээ хүлээгээд хугацаа хойшлогдоод байх нь.Тендерийн үнэлгээний хорооны гишүүд тендерийн бичиг баримтыг боловсруулах хугацааг товлоё.

**Н.Нямхүү:** Худалдан авалтыг хэдэн багц болгох, энэ 11 төрлийн тоног төхөөрөмжийг авах юм уу гэдэг талаар бид ойлголтоо авах хэрэгтэй байх.

**М.Баяраа:** АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораториос мэдэж байгаа хүн нь мэдээллийг хурдан гаргаад өгчих хэрэгтэй. Тэрийг аваад мэдээллээ гишүүддээ өгөх үү. Тэгэхээр хугацаа алдахгүй ажиллах талаар нарийн бичиг анхаарах хэрэгтэй.


**Тендерийн жишиг бичиг баримтыг боловсруулах талаар,**

**Д.Даваабаяр:** Тендерийн жишиг баримт бичгийн төслийг боловсруулаад гишүүддээ хүргүүлээд гишүүдийн саналыг авч нэгтгэн, дахин нэг хуралдан санлуудаа хэлэлцээд, эцэслэн боловсруулах боломжтой. Гол нь техникийн тодорхойлолт байгаа юм. Дээр нь оролцогчдод ямар ямар шалгуур, үзүүлэлт тавих вэ гэдэг дээр гишүүд саналаа гарган хэлэлцэн, шийдвэрлэх шаардлагатай.


**Шийдвэрлэсэн нь:**

1. Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лабораториос бүтээгдэхүүнтэй холбоотой бүх тавигдах шаардлага, мэдээ мэдээллийг тендерийн үнэлгээний хорооны нарийн бичиг авч нэгтгэх.
2. Тендерийн жишиг баримт бичгийн төслийг боловсруулах, гишүүдэд хүргүүлэх, дараагийн үнэлгээний хорооны хурлыг товлох.

Танилцсан:

Тендерийн үнэлгээний хорооны дарга  М.Баяраа

Гишүүд:

 Н.Нямхүү

 Н.Цогтбаяр

Ц.Эрдэнэбаяр

 Ц.Цэрэндаш

 П.Бат

Тэмдэглэл хөтөлсөн:

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга 

Д.Даваабаяр

## Тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл №02

2018 оны 2 дугаар сарын 12 өдөр

Хурал хийсэн газар: УУХҮЯ-ны 202 тоот хурлын өрөө, 14:00-17:30 цаг

Хуралд оролцсон гишүүд: Тендерийн үнэлгээний хорооны дарга М.Баяраа, гишүүн Н.Нямхүү, Н.Цогтбаяр, Ц.Эрдэнэбаяр, Ц.Цэрэндаш, Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Д.Даваабаяр нар оролцож 85%-ийн ирцтэй хуралдав.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Төсвийн хөрөнгөөр 2018 онд Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн бичиг баримтын төслийг хэлэлцэн, гишүүдийн саналыг нэгтгэн, тендерийн баримт бичгийг эцэслэн боловсруулах
2. Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолттой танилцах, эцэслэн батлах.

**Д.Даваабаяр:** Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичиг: Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн Үнэлгээний хорооны ээлжит хурлыг зарлан хуралдуулж байна. Үнэлгээний хорооны гишүүн П.Бат хөдөө ажлаар явж байгаа тул оролцох боломжгүйгээ хэлсэн байгаа, цахимаар мэдээлэл, хурлын зарыг хүргүүлсэн, бусад бүх гишүүд ирсэн байна. Үнэлгээний хорооны бүх гишүүдэд “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторын тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер”-ын бичиг баримтын төслийг цахимаар хүргүүлсэн байгаа. Энэ хурлаар тендерийн баримт бичгийг дэлгэцээр эхнээс нь хараад гишүүд тус тусын саналаа тусгуулаад баримтаа эцэслэх, хавсаргах техникийн тодорхойлолттой танилцан саналаа өгч, бичиг баримтаа эцэслэе.

За эхлээд “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж”-ийнхөө техникийн тодорхойлолтыг би дэлгэц дээр гаргачихлаа, Ц.Эрдэнэбаяр гишүүн эхнээс нь танилцуулаад явах уу?

**Ц.Эрдэнэбаяр:** Техникийн тодорхойлолт хэлэлцэхээс өмнө би гишүүдэд жишиг үнийг тооцож гаргасан талаар товч тайлбар өгье гэж бодож байна. Бид манайд шаардлагатай эдгээр багаж тоног төхөөрөмжийн жишиг үнийг гаргахдаа бидэнтэй хамтран ажиллаж байгаа БНСУ-ын К-Петро гээд яг манай агентлагтай ижил төрийн байгууллагаас тэдний шинжилгээний лабораторид хэрэглэж байгаа багаж, тоног төхөөрөмжийн үнийг асууж, тодруулж гаргасан. К-Петрогийн лабораторид хэрэглэж байгаа багаж, тоног төхөөрөмжийн ихэнхи нь АНУ-д үйлдвэрлэгдсэн байдаг юм билээ. АМГТГ болон К-Петро хооронд байгуулсан хамтран ажиллах Санамж бичгийн хүрээнд бид сургалт, судалгаа, туршлага солилцох, газрын тосны бүтээгдэхүүний хяналтын системийг сайжруулах, лабораторийн шинжилгээний үр дүнг сайжруулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна. Тиймээс тэд нараас өөрсдийн хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийн үнийг бодитой хэлсэн гэж бодож байгаа, мөн дээрээс нь манай хүмүүс интернетээс үнэ судалсан байгаа.

**Ц.Цэрэндаш:** Энэ үнэ чинь газар дээрх үнэ нь юм уу?

**Ц.Эрдэнэбаяр:** Наад үнэ бол АНУ-аас Солонгос улсад импортоор орж ирсэн үнэ гэж ойлгож болно. Энэ үнээр энэ багажыг АНУ-аас Монгол руу импортлоод оруулж ирэхэд энэ хавьцаа юмаа л гэж харж байгаа үнэ.

**Ц.Цэрэндаш:** Аан тэгвэл тээвэр энэ тэр нь манайд ямар байдгийн

**Ц.Эрдэнэбаяр:** Бид анх 17 нэр төрлийн багажийг 2,6 тэрбумаар авахаар санал хүргүүлж байсан. Энэ үнээр багаж төхөөрөмжөө шинэчилснээр манай лаборатори автобензин, дизель түлш, газрын тосны түүхий тос нь дээр хүртэл цогц шинжилгээ хийнэ гэдэг саналаа явуулж байсан. Гэвч төсөв маань 1,2 тэрбум гээд батлагдчихсан. Тэгэхээр бид нийт 17 төрлийн багажнаас хасаж, батлагдсан төсөвт өртгөөр 11 төрлийн багаж авахаар тооцоолол хийсэн байгаа. Тээврийн хувьд АНУ-аас Солонгос хүрэх, манайд ирэх 2-т зөрүү харьцангуй бага байх гэж бодож байгаа.

За ингээд техникийн тодорхойлолтын талаар яриад явъя. Гишүүдэд энэ цаасыг тарааж өгсөн үү, тоног төхөөрөмжийн жагсаалтыг, энэ дээр ярья. 1-рт GC (PONA) төхөөрөмжийн нэр нь, 7890A нь загвар нь. Энэ загвар өөрөө А, В, С гээд 3 янз байгаа, манай үндсэн тоног төхөөрөмжид 7890A нь таарах юм, энэ нь харин аль ч улсын байж болно. Тоо ширхэгээ бичсэн байна хувилбарууд гэж байгаа энэ нь жишээ нь Thermo fisher Scientific (Thermo Scientific TRACE 1300G) гэсэн нь үйлдвэрлэгч буй бусад орнуудтай дүйцхүйц хувилбарууд байж болох юмаа гэдгийг, тодорхойлох төрөл гэдэг дээр нь бид яг юу үзэх гэж байгаагаа зааж өгсөн тухайлбал автобензин ээ үзэх юм автобензинийхээ элементүүдийг GC-хээ багаж дээрээ үзэж авах юмаа. Стандартыг оруулж өгсөн байгаа, ямархуу үйлдвэрлэлийн стандартууд байх юм бэ гэдгийг ингэж багаж тус бүр дээрээ нэг бүрчлэн гаргаад хэрэглээнд юу байхийн стандарт нь ямар байхын, тоног төхөөрөмжийн тохируулга нь ямар байхын автомат байх юм уу, нэг багц мэдээллийн сантай байх юм уу ард талд нь программ хангамжтай байх уу, кодтой эсэх гээд нэг бүрчлэн нарийвчлаад гаргаад өгчихсөн. Тэгэхлээр бидэнд техник талаасаа иймэрхүү үзүүлэлтүүд байх хэрэгтэй гэдгийг гаргаад өгсөн байна.

**Н.Нямхүү:** Танай байгууллагаас гаргаж ирсэн энэ техникийн тодорхойлолтыг мэргэжлийн хүмүүс нь гаргаад ирчихсэн зүйлийг бид ямар нэгэн өөрчлөлт хийж чадахгүй харагдаж байна. Би санхүүгийн хүний хувьд юуг харж байна вэ гэхлээр энэ тоног төхөөрөмжийн үнэнд суурилуулах, ашиглалтанд хүлээж авах тохиргоо энэ тэр, сургах, дадлагажуулах зардал орсон уу гэдгийг тодруулж, тэрийг бодож үзсэн үү гэж хэлэхээр байна.

**Д.Даваабаяр:** Та хэд маань бас сайн хараарай. Энд техникийн шаардлага, үзүүлэлт 2 нь байгаа энэ дээр сайн хараад энэ 2 маань бас нэг нэг рүүгээ орчихсон байх вий

**Ц.Эрдэнэбаяр:** Энэ нь дээр манай лабораторийнхон бүгд суусан, бүр нүүрсний хэд маань ч ажилласан. Яамнаас Д.Даваабаяр мэргэжилтэн ч суугаад мэдээллээ нэгтгээд гаргаж ирсэн.

**Д.Даваабаяр:** Тендерийн жишиг баримт руугаа орох уу. Холбогдох үйлчилгээний жагсаалт ба гүйцэтгэлийн хуваарийг харъя.

**Н.Нямхүү:** Хүргэлт, угсралт суурилуулалт, шалгалт тохируулга, сургалт зааварчилгаа, баталгаат хугацаа гэж байна эдгээр хугацаанууд нь хүргэлт хэзээ хийхээр төлөвлөж байгаатайгаа уялдаад л хугацаагаа тавъя. Гэрээ байгуулсан өдрөөс хойш хэд хоногт оруулж ирэх бэ гэдгээ бүгдээрээ тохирчихвол, нийлүүлэгч гаднаас захиалж импортоор оруулж ирж байгаа учраас хамгийн багадаа л 45 хоног байх болов уу.

**Ц.Цэрэндаш:** Тэгж таарна, тендер хэзээ зарлаж, хэзээ гэрээ байгуулах вэ гэдгийг тооцоод хоногоо тооцоод явчихад болно.

**Д.Даваабаяр:** 7 сарын 1 гэхэд хүлээж авч болох нь. За хугацааг хэдэн гэх үү, 7 сарын 10-наар. Угсралт суурилуулалт бол 14 хоногт л багтаачихна даа.

**Н.Нямхүү:** 7 сарын 31-ээр тавих уу. Шалгалт тохируулга, сургалт зааварчилгаа бол сараас хэтрэхгүй болов уу.

**Д.Даваабаяр:** Баталгаат хугацаа гэдгийг ямар хугацаагаар тавих уу.

**Ц.Эрдэнэбаяр:** Барилгын ажил дээр бол 3 жил гээд заасан байдагтай адил бараа нийлүүлэхэд баталгаат хугацаа гэж заасан албан ёсны хугацаа байна уу.

**Н.Нямхүү:** Сайн мэдэхгүй байна. Электрон бараа нь хугацаа 1 жил гээд нийтлэг байдаг, ТШӨХ-ийн 19-16 бас тасралтгүй ажиллагааны нэг хугацаа байсан тэр хугацааг бас тодруулах шаардлагатай байх. Энэ бол тоног төхөөрөмжийн элэгдлийг тооцохтой холбоотой хугацаа болов уу гэж би ойлгосон. Энэ 2 хугацаа нь дээр тодруулах уу Эрдэнэбаяр дарга.

**Д.Даваабаяр:** За цааш явъя. ТШӨХ-ийн 4.3-д ямар ямар тодорхойлолтуудыг авах шаардлагатай байна. Гэрчилгээний хуулбар, татварын тодорхойлолтууд байх уу.

**Ц.Цэрэндаш:** Байсан нь зөв.

**Д.Даваабаяр:** Шүүхийн энэ 3 газраас тодорхойлолт авах шаардлагатай юу

**М.Баяраа:** Шүүхийн бичиг арай олон бодоод байна, Шүүхийг эцсийн шийдвэр гартал гэм буруутай гэж үзэхгүй, 3 гэдэг нь арай олон бичиг авах болоод байх шиг байхын

**Ц.Цэрэндаш:** 2 тодорхойлолтыг л аваад бадаг юм байна лээ, Эхлээд аль нь байх вэ гэдгээ тодорхой болгочихвол үнэлэхэд амар болчихно.

**Н.Цогтбаяр:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт, харъяа шүүхийг тодорхойлолт байхад болно.

**Н.Нямхүү:** Хаанаас оруулж ирэх вэ гэдэг дээр бид улс заахгүй техникийн тодорхойлолт дээр дүйцхүйц гээд тодотгоод явчихна, тендерт хэр их оролцогч оролцох бол гэдэг үүднээс тендерийн бичиг баримт дээр шалгуураа хэрхэн тогтоох вэ, шаардлага хангасан оролцогчдыг оролцуулахын тулд.

**Д.Даваабаяр:** Дараагийнх нь энэ хараад өөрчлөлт оруулах дээрээ саналаа хэлээд яваарай, би засаад явна шүү

**Ц.Цэрэндаш:** Ирүүлж байгаа бичгүүдэд бүгдэд нь хуудас бүрт тамга дарах шаардлагагүй харин дугаарласан байх хэрэгтэй, хуулиндаа ч тийм байгаа, дугаарлагдсан бичгээ гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлага дээр

**Н.Нямхүү:** Ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлага дээр үнийн дүн хамаагүй гэрээ, гэрээ дүгнэсэн актыг хавсаргах гэдгийг заая

**Ц.Цэрэндаш:** Наториатаар баталгаажуулах гэж заах хэрэгтэй

**М.Баяраа:** Наториатаар баталгаажуулах шаардлагатай юу.

**Ц.Цэрэндаш:** Шаардлагатай л даа.

**Д.Даваабаяр:** Баталгаат хугацаа.

**Ц.Цэрэндаш:** Баталгаат хугацаанд тоног төхөөрөмжийн шаардлагатай засвар үйлчилгээг үнэ төлбөргүй хийж гүйцэтгэнэ, Авчраад ашиглалтанд оруулах гэтэл ямар нэгэн доголдол гарвал нийлүүлж байгаа газар бүрэн хариуцан сольж өгнө шүү дээ

**Д.Даваабаяр:** Санхүүгийн чадавхийн талаарх заалтуудаа тодорхой болгоё, энэ төсөлдөө сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогыг санал болгож буй үнийн дүнгийн 50% гэсэн байгаа

**М.Баяраа:** Борлуулалтын орлогыг тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна гэж бичихгүй бол нийлүүлэх төлбөрийн чадваргүй газар оруулж ирчихээд тоног төхөөрөмжөө нийлүүлж чадахгүй байх вий, урьчилгаа өгөхгүй биз дээ

**Н.Нямхүү:** Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого гэх үү, аль нэг жилийн борлуулалтын орлогын гэх үү. Өөрсдөө оруулж ирэх чадвартай компани байх шаардлагатай.

**Д.Даваабаяр:** жишиг баримт дээр үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо гэдийг 5 гэсэн байна.

**М.Баяраа:** Энэ 5 жил гээд заачихлаар үнэлгээ хийхдээ 5 жилд ижил төстэй ажил хийгээгүй гэдгээрээ шууд хасагдчих нь байна ш дээ. Ижил төстэй ажлын туршлага дээр энийг заачихаад байгаа ш дээ, тэгэхлээр энэ заалт байх шаардлага юу байна.

**Д.Даваабаяр:** Тендерийн баталгааны дүнг 1-2 хувь гэж байгаа, хэдээр баталгааны дүнгээ тавих уу

**Н.Нямхүү:** 2% байх уу 1,5% байх уу

**М.Баяраа:** 1,2 тэрбум төгрөгийн тендерт материал ирүүлж байгаа компанийн хувьд наад хувь тийм нөлөө байхгүй ээ хэд болж байгаа юм.

**Н.Нямхүү:** 2% нь 24,0 сая 1,5% нь 18,0 сая болж байна.

**М.Баяраа:** 24,0 саяаар нь баталгаагаа гаргуулъя

**Ц.Цэрэндаш:** Тэр зөв

Шийдвэрлэсэн нь:

1. Тендерийн бичиг баримтыг эцэслэн боловсруулж, гишүүдэд танилцуулан албажуулах.
2. Тендерийн урилга, бичиг баримтыг яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд цахим сайтад байршуулж, тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг эхлүүлэх.

Танилцсан:

Тендерийн үнэлгээний хорооны дарга  М.Баяраа

Гишүүд:

 Н.Нямхүү  
 Н.Цогтбаяр  
Ц.Эрдэнэбаяр  
 Ц.Цэрэндаш  
П.Бат

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга:  Д.Даваабаяр



УУЛ УУРХАЙ, ХҮНД  
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2018.03.28 № 2/449  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай яамнаас зарласан УУХҮЯ/201801001 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерт оролцогч “Грийн Химистри” ХХК-иас уг тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд холбогдох гомдлыг тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендерийн баримт бичиг, тайлбар тодруулгаас үзэхэд тухайн тендерээр худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн шаардлага, тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг боловсруулахдаа тодорхой нэг үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүний техникийн үзүүлэлтийг нэг бүрчлэн заасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөл тавихгүй” гэж заасныг зөрчиж тендерт оролцогчдын өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3-т “Зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах” гэж заасны дагуу тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т нийцүүлэн холбогдох өөрчлөлт оруулж хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдэж, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

Хувийг: Грийн химистри ХХК-д

ОРОН ТООНЫ ГИШҮҮН  С.ЦОГТГЭРЭЛ

0001254



“БАЯНГОЛ МЕД” ХХК-д

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>

2018.04.02 № 04/891  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Мэдээлэл хүргүүлэх тухай**


“Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” УУХҮЯ/201801001 дугаартай тендерийг “Грийн Химистри” ХХК-иас гаргасан гомдлын дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/368 тоот албан бичгээр түдгэлзүүлээд байсан билээ.

ШӨХТГ-аас тухайн тендерийн тоног төхөөрөмжийн техникийн шаардлага, үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т нийцүүлэн холбогдох өөрчлөлт оруулан, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2/449 тоот албан бичгээр манайд мэдэгдээд байна.

Иймд тус мэдэгдлийн дагуу тендерийн бичиг баримтын тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт хэсэгт холбогдох өөрчлөлт оруулан ШӨХТГ-т хүргүүлээд байна.

ШӨХТГ-аас ирүүлсэн албан бичгүүдийг хавсаргав.  
Хавсралт & хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ХОРООНЫ ДАРГА \_\_\_\_\_ М.БАЯРАА





“ЭМ ПИ АЙ КОНСАЛТАНТ” ХХК-д

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>

2018.04.02 № 04/892  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

“Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” УУХҮЯ/201801001 дугаартай тендерийг “Грийн Химистри” ХХК-иас гаргасан гомдлын дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/368 тоот албан бичгээр түдгэлзүүлээд байсан билээ.

ШӨХТГ-аас тухайн тендерийн тоног төхөөрөмжийн техникийн шаардлага, үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т нийцүүлэн холбогдох өөрчлөлт оруулан, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2/449 тоот албан бичгээр манайд мэдэгдээд байна.

Иймд тус мэдэгдлийн дагуу тендерийн бичиг баримтын тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт хэсэгт холбогдох өөрчлөлт оруулан ШӨХТГ-т хүргүүлээд байна.

ШӨХТГ-аас ирүүлсэн албан бичгүүдийг хавсаргав.  
Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ХОРООНЫ ДАРГА \_\_\_\_\_

М.БАЯРАА





**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mmhi.gov.mn>


2018.04.02 № 04/890


танай 2018.03.28 ны № 2/449 -т

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАРТ**

Танай 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2/449 тоот албан бичгийн дагуу УУХҮЯ/201801001 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерийн бичиг баримтын тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт хэсэгт холбогдох өөрчлөлт оруулан үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.  
Хавсралт 29 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ХОРООНЫ ДАРГА  М.БАЯРАА



08 0513